

**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр				Улаанбаатар хот	
№	Зорилт	Хэрэгжүүлэх арга зам	Биелэлт	Зарцуулсан төсөв	Хувь
1	2	3	4	5	6
1	Ажлын байр, ажиллах нөхцлийг сайжруулах	Албан хаагчдын тав тухтай ажиллах орчин бий болгохын тулд засвар тохижилтыг хийж өрөөний чийгшил, гэрэлтүүлэг, цэцэгжүүлэх	Манай байгууллага нь Соёлын төв өргөөний Г байрны 12 давхрын 67м2 талбай бүхий №1201, 1202, 1203, гурван өрөөг 2016 оноос эхлэн конторын зориулалтаар түрээслэн, Г-6046231 дугаартай түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байна. Байгууллага нь түрээсийн гэрээний эрх үүргийнхээ дагуу эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, урсгал засвар үйлчилгээг бүрэн хариуцаж өөрийн төсвийн хөрөнгөөр засварын ажлыг хийж гүйцэтгэж ирсэн. Фермерийн цогцолборт байрлах ажлын байрны цэвэрлэгээ, ариутгалын ажлыг тогтмол явуулахад шаардлагатай материалаар ханган засвар үйлчилгээг цаг тухай бүрт нь хийж ирсэн. Ундны гүний худгийг засварлан цахилгааны утас, пускателийг солисон байна. Сургалтын төвийн тог цахилгааныг бүрэн засварлан ажилласан байна.	2,500,000	100%
2		Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай техник төхөөрөмж, бичиг хэрэгслээр хангах	2022 онд байгууллагын ажилтан албан хаагчдын ая тухтай ажиллах, тохилог орчин нөхцлийг бүрдүүлж техник тоног төхөөрөмж сэлбэн сайжруулах, бичиг хэргийн хангамжийн материалаар ханган ажиллаж байна. 2022 оны 4 улирлын байдлаар Бичгийн хэрэгсэл, лицензтэй вирусны программ, санхүүгийн программ сунгалт, интернетийн үйлчилгээ, компьютер формат зэрэг ажил үйлчилгээнд нийт 3,639,500 төгрөгийг зарцуулсан байна.	3,639,500	

3	Шагнал урамшил	Албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, үр дүнгийн гэрээг үнэлэн олгох урамшил, тэмдэглэл болон уламжлалт баярыг утган шагнаж урамшуулах, төрийн дээд болон салбарын одон медалиудад тодорхойлох зэрэг арга хэмжээг зохион байгуулах.	2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/07 дугаар тушаалаар Байгууллагын дотоод журмын 7.1.9 дэх заалтыг үндэслэн, Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын 16 хүртлэх насны нийт 15 хүүхдэд 300,000 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл өгсөн. Албан тушаалын бүрэн эрхээ үр дүнтэй биелүүлж, өндөр амжилт гаргасан ажилтан, албан хаагчдын гавьяа зүтгэлийг нь үнэлэн Фермер Н.Туул, туслах малчин Г.Баярсайхан нарыг Ардын хувсгалын 100 жилийн ойн баяр наадмыг тохиолдуулан "Хүнс, хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан цол тэмдэг"-ээр шагнаж урамшуулсан.	300,000	100%
4	Эрүүл мэнд, биеийн тамир спортын арга хэмжээ	Ажилтан, албан хаагчдыг биеийн тамир, спортоо хичээллүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх	Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжиж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулдаг Улаанбаатар марафон олон улсын гүйлтэд байгууллагын 5 албан хаагчид идэвхтэй оролцож Нярав Б.Дорждэрэм 5 км-ийн гүйлтэд амжилттай оролцож, 1321 тамирчдаас 38-р байр эзэлж БАТЛАМЖ гардан авсан. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын нэрэмжит нутгийн захиргааны байгууллагуудын спортын IV наадмын 3 дугаар бүсийн тэмцээний зохион байгуулалтад идэвхтэй оролцож байгууллагын хамт олноос 350,000 (гурван зуун тавин мянган) төгрөг бооцооны мөнгөн тусламж үзүүлсэн.	350,000	100%
5		Албан хаагчдын дунд эерэг уур амьсгал бүрдүүлж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" Үндэсний хөдөлгөөний хүрээнд өрнүүлж буй "Ногоон хот –Иргэний оролцоо мод тарих аяны хүрээнд –Айцын аманд- ойжуулах, ойн зурвас байгуулах ажилд нийт албан хаагчид мод, бут сөөг тарьж хамтран ажилласан.Мөн Фермерийн цогцолборт албан хаагчдын дэмжлэгээр ногоон байгууламжийн арчилгааг хийж, 5 мод тарьсан.	300,000	100%

7	Шинээр гэр бүл болсон мөн тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулан тэтгэмж олгох	Тус байгууллагын Төслийн менежер Г.Пүрэвсүрэн нь 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөр тасалбар болгон тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул төрийн албанд ажилласан жилийн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж 21,005,500.00 төгрөгийг олгохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн Байгууллагын дотоод журмын 7.1.7 дах заалтыг үндэслэн өндөр насны тэтгэвэр тогтоолгож буй Төслийн менежер Г.Пүрэвсүрэнд 200,000 мянган төгрөгний мөнгөн тусламж үзүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	21,205,500	100%
8	Байгууллагын эд хөрөнгийг хариуцаж байгаа манаачид өвлийн улиралд түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлэх	Тус байгууллагын хөдөлмөрийн дотоод дүрэм журмын 7.1.11 дүгээрт зааснаар Манаач, туслах малчин Г.Баярсайханд жилд 1 удаа 5 тн түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн.	2,664,000	100%
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ				
100%				

ТАНИЛЦСАН:
ДАРГА

ХЯНАСАН:
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



Н.УУГАНБАЯР

Г.ПҮРЭВСҮРЭН

Б.ОТГОНЖАРГАЛ